



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

**Хөдөлмөрийн дотоод журмыг  
шинэчлэн батлах тухай**

Хөдөлмөрийн тухай хуулийн 130 дугаар зүйл, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдын хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 149 дүгээр тогтоолын хавсралт “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн, үйлдвэрлэл технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 5.1.8 дах хэсэг, “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын Хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйл 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын Хөдөлмөрийн дотоод журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

Хоёр. Энэхүү журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах, сургалт зохион байгуулах ажлыг Захиргаа, санхүү төлөвлөлтийн хэлтэс /Р.Дүүрэнбаяр/-т үүрэг болгосугай.

Гурав. Тушаал батлагдсантай холбогдуулан “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын даргын 2016 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/32 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Дөрөв. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Д.Алтангэрэл/-д даалгасугай.

ДАРГА



Х.ЭРДЭНЭБИЛЭГ

3150000076